

МОНГОЛ АРДЫН БИЧГИЙН АМАН ХЭЛ

WRITTEN ORAL LANGUAGE OF MONGOLIAN PEOPLE

Д.Боролзой

Товч агуулга: Энэ өгүүлэлд бичгийн хэлээр тэмдэглэж байгаа боловч аман яриагаар ярьж буй мэт интернэт орчинд илрэх бичгийн аман хэлний тухай өгүүлсэн болно. Аман яриа мөртөө бичиг шиг хэлбэрээр илрэн гарч буйг эрдэмтэд “аман бичгийн хэл” гэж нэрлэдэг. Тэгвэл зохиогч интернэт орчин дахь бичгээр тэмдэглэсэн аман яриаг “бичгийн аман хэл” хэмээн томъёолжээ.

Түлхүүр үг: Аман бичгийн хэл, бичгийн аман хэл, интернэт хэл шинжлэл, нийгмийн сүлжээ

Keywords: Oral written language, written oral language, internet linguistics, social network, mongolian linguistics

0. Удиртгал. Алдарт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов анхланмонгол ярианы хэлэнд буй нэгэн онцлогийн талаар өгүүлсэн нь “аман бичгийн хэл” юм. Үүний талаар хожим Б.Ринчен мөн “Монгол ардын аман бичгийн хэл” өгүүлэлдээ дэлгэрэнгүй бичиж нийтлүүлжээ. Энэхүү аман бичгийн хэл хэмээх зүйлийн гол онцлог нь огт үсэг бичиг мэддэггүй үлгэрч туульч нар үлгэр туулиа хэлэхдээ яг л бичиг үсэг мэддэг мэт, тэр хэлж буй зүйл нь ч эгээ л бичгээр бичсэн зүйлийг дуудан уншиж буй мэт байдаг байжээ.

Интернэт хэмээх зүйл бий болсноор бидний эргэн тойронд маш олон зүйл хувьсан өөрчлөгдөж байгаагийн нэгэн жишээ нь хэл юм. Монгол хэл ч энэхүү интернэт орчинд болж буй хувьсал өөрчлөлтөөс ангид байсангүй. Фэйсбүүк (Facebook), Твиттер (Twitter) зэрэг нийгмийн сүлжээний сайтууд (Social network site) нь орчин үеийн хүмүүсийн харилцааны нэгэн том талбар болжээ. Ингэж харилцахдаа хүмүүс сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, цаг хугацаагаа хэмнэх, бичих орон зайдаа аль болох олон үсгийн тэмдэгтүүдийг багтаах зэрэг хэрэгцээ шаардлагаас үүдэн “гэж байгаа” гэхийг “гэжүүгаа”, “үгүй” гэхийг “гүэ”, “яах вэ дээ” гэхийг “яахүдээ”, “тэгэх үү” гэхийг “тэхүү”, “сурах юмсан” гэхийг “сурхымсан”, “байна шүү дээ” гэхийг “байшд”, “зэвүүн” гэхийг “зивүүн” гэх мэтээр үгийг хураан товчлон бичих, этгээд хэв маяг гаргах, аялгын өнгө аяс оруулах зэрэг үзэгдэл түгээмэл байна.

1. Аман бичгийн хэл. Аргын улирлын он тоолох ёсны нэгэн мянга есөн зууны жаран нэгэн онд “Шинжлэх ухааны академийн мэдээ” сэтгүүлийн хоёрдугаарт академич Б.Ринчен “Монгол ардын аман бичгийн хэл” (Ринчен, 1961) хэмээх нэгэн сонин сайхан өгүүлэл нийтлүүлсэн байдаг билээ. Эл өгүүлэлд эрт цагийн бичиг үсэг мэдэхгүй үлгэрч хүмүүс үлгэр тууль, ерөөл магтаалаа энгийн ярианы хэлнээс огт өөрөөр бичгээр тэмдэглэсэн зохиолыг дамжуулан хэлж байгаа мэт тийм боловсронгуй найруулгатай, монгол бичгийн хэлний байдалтай хэлдэг тухай өгүүлжээ. Энэхүү “манай монгол ардын аман зохиолд үлгэр тууль, ерөөл магтаалд тодронхон гардаг эрхэмсэг сайхан хэлийг” (Ринчен, 2015 а: 116) аман бичгийн хэл хэмээн нэрийддэг байна.

Аман бичгийн хэлний онцлогийн талаар академич Б.Ринчен “Үг нь бас шүлэглэсэн байдалтай, яруу сонсголонтой, цэцэн мэргэн эрхэмсэг сайхан нь, намбатай эгшиглэн хүүрнэх аялгуундаа мөн тааран зохилдсон, нарийн хэмжээтэй зоригтой сонгож хэрэглэсэн

үг байдаг байна. Найруулга нь бас үг олдож өхгүйд толгой түрүү гар хуруугаа гозгонуулан ангалзаж байдаг хамаа намаагаа алдсан хар ярианаас ондоо, нарийн чанд дүрэмтэй журамтай, нарийн тогтолцоотой, баялаг үгтэй бэлэн сайхан зүйрлэлтэй, дүрслэн урлах их чадалтай, өндөр их соёл боловсролын шинж бүрэлдсэн хэлтэй байдаг байна” (Ринчен, 2015 а: 114) хэмээн өгүүлжээ.

Энэ аман бичгийн хэлний онцлогийн тухай анх түрүү академич Б.Ринчен ийнхүү өгүүлсэн байдаг бол монголчууд аман зохиолдоо бичгийн хэлний хэл хэрэглэдгийг анхлан Зөвлөлтийн монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов ажиглан тэмдэглэжээ. Энэ талаар өгүүлбэл “1925 онд, манай ардын засгийн эхний үеэр Хүрээ, Хэнтий хавиар угсаатны судлал, хэлний шинжлэлийн судалгаа хийж, тайлан илтгэлээ 1926 онд “Северная Монголия, Этнолого-лингвистические исследования в урге, ургинском и Кентейским районах. Ленинград, 1926” гэдэгтээ халхын зүүнд “ном бичгийн хэлээр бүтэн өгүүлбэрийг найруулан тохиолддог байна” гэж 9-р талд тэмдэглээд, жишээ болгохдоо, аялгуугий нь орос галигаар тэмдэглэсэн нь:

*Мануу Монгол хэмээгчи
Маши ундур изагууртээ
Манай Монголын Чингис хаан
Маши ундур алдартээ*

гэдэг яг бичгийн хэлбэртэй үг

*Намрын сардаа мордлоо даа
Нийслэл хүрээгий нь авлаа даа*

гэдэг дуунд байсныг тэмдэглэн дурсч, бичиг хараад уншиж байсан юм шиг бичгийн хэлний хэлбэртэй юм дайралдлаа гэж бичжээ.

Хожим, Зөвлөлтийн эрдэмтэн Козин, нууц товчоог судлахдаа, удиртгалд нь “Монгол бичгийн зохиолын анхных нь жижиг нутаг усны аман зохиолын зүйл хөгжсөн аймаг хоорондын аман бичгийн хэл болж ирсэн зүйлийг үндэслээд, нэгэнт тогтсон аман бичгийн хэлийг бичгээр тэмдэглэсэн зүйл болно” гэж Сокровения сказания, Москва-Ленинград, 1941 г, 51-р талд өгүүлсэн нь Владимирцов авгайн шинжлэн ажилласнаас алхам ахиж монголын аман зохиолын хэл нь аман бичгийн хэл болж тогтоод, бичгээр тэмдэглэхэд ном бичгийн хэл болсон гэж сүрхий шинжилжээ. Энэ чухал шинжлэлийг манай ардын аман зохиолын эрхэмсэг хэлбэр болсон үлгэр, тууль, ерөөл, магтаалын хэл цөм батлан гэрчилж буйг тэмдэглэлтэй” (Ринчен, 2015 а: 116-117) гэсэн байна.

Монгол ардын аман бичгийн хэл гэдгийгтовчоор илэрхийлбэл огт бичиг үсэг мэдэхгүй үлгэрч туульч хүн мөн л огт бичиг үсэг мэдэхгүй багш нараасаа сурсан үлгэр туулиа хайлахдаа бичгийн хэлний мэт хэлбэрээр дамжуулж буйг хэлж байна. Жишээлбэл, 1928 онд Засагт хааны нэгэн өвгөнөөс Б.Ринчений тэмдэглэж авсан даллагын ерөөлийн

*“Алтан Сүмбурваа нуулундунь ургуксан
Агар зандан моддоноос
Анхан тэргүүлэж ургуксан
Заххын алтан мөчиригээр
Уралажи кхийксэн
Хан огторгуйдуни налис дэвикчи
Хан Гардийн заххын өдөөр
Содлон кхийксэн
Эрдэни нигуур чимэглэн барилдуулуксан
Эрдэниин оюгуун цагаан суммаа!*

Даллаксан даллага чини,

Далай мэтэ мэлмэлзүүлээд” (Ринчен, 2015 б: 229-230)

гэсэн үгэнд *ургуксан* (ургасан), *мөчириээр* (мөчрөөр), *уралажи* (урлаж), *нигуур* (нүүр) гэх зэргийн ерийн ярианы хэлээр ингэж хэлдэггүй харин монгол бичгээр тэмдэглэсэн зүйлийг уншиж байгаа мэт тэр хэлбэрээр тааралддаг байна.

2. Бичгийн аман хэл. Интернэт хэмээх зүйл бий болсноор бидний эргэн тойронд маш олон зүйл хувьсан өөрчлөгдөж байгаагийн нэгэн жишээ нь хэл юм. “Хэл бол үргэлж хувьсаж, хөгжиж, өөрчлөгдөж байдаг бараг л “амьд организм”. Кирил цагаан толгойг халх аман аялгад тулгуурлаж зохиосон боловч 60 жил өнгөрөхөд бичгийн, аман, хүүхдийн, уран зохиолын, албаны тэр байтугай мэссэж гар утасны хэл гэж салж байна” (Баабар, 2014). Монгол хэл ч энэхүү интернэт орчинд болж буй хувьсал өөрчлөлтөөс ангид байсангүй.

Энэ дэлхийн олон сая хүнийг өөртөө нэгтгэж чадсан Фэйсбүүк¹ (Facebook), Твиттер² (Twitter) зэрэг нийгмийн сүлжээний сайтууд (Social network sites) болон гар утасны мессежийн үйлчилгээ нь орчин үеийн хүмүүсийн харилцааны нэгэн том талбар болжээ. Ингэж харилцахад хүмүүсийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, хурдан бичих, цаг хугацаагаа хэмнэх, бичих орон зайдаа аль болох олон үсгийн тэмдэгтүүдийг багтаах зэрэг хэрэгцээ шаардлагаас нь шалтгаалан олон янзын бичлэгийн хэлбэрийг интернэтийн орчинд үүсгэж байна. Үүнийг дараах байдлаар тодорхойлж болох юм.

1. Ярианы хэлний дуудлагаар бичнэ. Ж: үгүй-гүү, тэгэх үү-тэхүү, гурван-гуруун г.м.
2. Ярианы урсгалд дагавар, сул үг зэрэг нь өмнөх үгийнхээ өргөлтөд захирагдан авиа зүйжсэн нэг үг болсныг тэр хэвээр нь бичдэг. Ж: харж байсан юм-харжийсийм, яах вэ дээ-яахудээ, гэж байна шүү дээ-гэжийшд г.м.
3. Өмнөх үгэндээ татагдан түүний өргөлтөд захирагдан бие даасан байдлаа алдан өргөлтөт үгийн нэг хэсэг болсноор нь бичдэг. Ж: авч ирэх-ацрах, морь руу-морьлуу г.м.
4. Сэтгэл хөдлөлийн өнгө аясыг илэрхийлдэг. Ж: кк-инээх, ваув-уулга алдах г.м.
5. Гадаад үгийг монгол хэлний дуудлагаар, этгээд хэв маягаар бичдэг. Ж: ресторан-ирстраан, пиво-пиав, клуб-хөлөөв, сигнал-чагнаал гэх мэтээр ярианы хэлээр бичсэн бичгийн хэлний нэгэн хэв маяг интернэт орчны харилцаанд бий болжээ.

Утга зохиолын хэлэнд бичгийн хэл, ярианы хэл гэсэн хоёр хэлбэр байдаг билээ. Бичиг нь яриатайгаа хэдий ойр байлаа ч яг тэр хэлдгээр нь бичдэггүй. Яагаад гэвэл аман ярианд үг хэллэгийг олон янзаар хэлж болдог. Өөрөөр хэлбэл ярианы хэл нь хөдлөнгө шинжтэй байдаг бол бичгийн хэл нь харьцангуй зогсонги байдаг билээ. Ийм учраас л зөв бичих дүрмийг мөрддөг билээ. Харин үүний эсрэгээр бичгээр бичсэн зүйлийг аман ярианд яг бичсэнээр нь дууддаггүй. Нийгмийн сүлжээнд олон нийтийн хоорондоо харилцаж байгаа бичгэн харилцааг ажиглахад алдаатай мэт, зөв бичгийн дүрмийг зөрчсөн мэт, бичгийн хэлний хэм хэмжээг баримтлаагүй мэт харагддаг. Бичгээр л тэмдэглэсэн болохоос амьд халуун ярианы уур амьсгал, өнгө аястай байдаг бөгөөд энэ өвөрмөц

¹ 2015 оны 7 сарын байдлаар фэйсбүүкт бүртгэлтэй хэрэглэгч 2 тэрбум давсан ба үүнээс идэвхтэй хэрэглэгч нь 1 тэрбум 490 сая байна. (Эх сурвалж:

https://en.wikipedia.org/wiki/List_of_virtual_communities_with_more_than_100_million_active_users)

² Эдүгээ твиттер дэлхийн хэмжээнд 2015 оны 3-р сарын 25-ны байдлаар 645 сая 750 мянган бүртгэлтэй хэрэглэгчтэй бөгөөд үүнээс идэвхтэй хэрэглэгч нь 289 сая байна. Хэрэглэгчдийн тоо өдөрт 135000-аар нэмэгдэж, сард твиттер хуудсаар 190 сая хүн зочилж, өдөрт 58 сая, минут тутам 9100 жиргээ хийгдэж байна. (Эх сурвалж: <http://www.statisticbrain.com/twitter-statistics/>)

“алдаатай” бичгэн харилцаа нь харилцагч хүмүүсийн дээрх зорилгыг бүрэн сайхан хангаж байгаа байдал нийгмийн сүлжээнд ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл бичиж л байгаа болохоос яриа гэж хэлж болно. Энэ байдлыг буруутгах боломжгүй бөгөөд учир нь нийгмийн сүлжээний сайтууд нь албан харилцаа биш хүмүүсийн хувийн харилцааны шинж төрхийг илүүтэй агуулдаг тул бичгийн хэлний хэм хэмжээг мөрддөггүй, мөрдүүлэх ч боломжгүй, бас шаардлагагүй тийм харилцааны талбар билээ. Аман яриа мөртөө бичиг шиг хэлбэрээр илрэн гарч буйг эрдэмтэд “аман бичгийн хэл” гэж нэрлэдэг. Тэгвэл интернэт орчин дахь бичгээр тэмдэглэсэн мөртөө уншихад яг л яриа мэт байдаг энэхүү харилцааны хэлбэрийг “бичгийн аман хэл” хэмээн томъёолж болмоор байна.

Бичгийн хэлэнд өрнөж буй энэхүү сонирхолтой үзэгдэл ганцхан монгол хэлэнд тохиолдоогүй нь лавтай. Техник технологийн дэвшлийн нөлөөгөөр энэхүү асуудал дэлхийн бүхий л хэлэнд тохиолдож байгаа бөгөөд харин ч үүнийг хүлээн зөвшөөрч хэрэглэж байгаа нь харагдах болов. Дэлхийн бусад хэлүүдэд, тухайлбал англи, орос хэлүүдэд ч байгаа энэ үзэгдлийг тухайн улсын хэлний судлаачид анзааран судалсан байдаг байна. Жишээлбэл, Английн хэл шинжлэлч Дэвид Кристал интернэт орчинд хэрэглэгдэж байгаа үг хэллэг, харилцааг *netspeak* гэж нэрлээд “интернэт нь хэл хэрэглээг нэг талаар асар ихээр өөрчлөхийн зэрэгцээ нөгөө талаар хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна... ..ярианы хэл, бичгийн хэлний шинж чанарыг тус тус гарган үзүүлж интернэтийн хэл нь ярианы хэл, бичгийн хэлний шинжийг зарим талаар зэрэг хадгалсан байдаг ч өөрийн өвөрмөц онцлогтой байдаг учир түүний давуу тал, хэлний хөгжилд нөлөөлөх нөлөө өндөр болохыг өгүүлсэн. Тухайлбал интернэтийн харилцаа нь чөлөөтэй, албадлагын бус шинжтэй, харилцан идэвхитэй, заавал хэл зүйн болон бусад дүрэмд захирагдах албагүй, баялаг шинжтэй байдаг” (Энхмаа, 2015: 13) гэжээ. Мөн Оросын хэл шинжлэлч С.Е.Александрович залуучуудын гар утасны мессэжийн хэлийг судалсан бөгөөд “*хорошо* гэх үгийг дуудлагаар нь *харашо*, *здесь* гэхийг *сдес* гэх мэтээр бичихийн зэрэгцээ *Ok, boyfriend* гэх мэт гадаад үг хэллэг хэрэглэж байна гэсэн. Судлаач интернэтийн хэлийг *устно-письменная речь* буюу *бичгийн хэлбэрээр илрэх ярианы хэл* гэж тодорхойлсон” (Энхмаа, 2015: 22) байна.

3. Дүгнэлт. Академич Б.Ринчен монгол хэлэндэх “аман бичгийн хэл” хэмээх нэгэн сонирхолтой үзэгдлийг судлаад үүнийгээ “*Монгол ардын аман бичгийн хэл*” хэмээн тодорхойлжээ. Тэгвэл интернэт орчинд өрнөж буй “бичгийн аман хэл” хэмээх энэ үзэгдлийг ч гэсэн “*Монгол ардын бичгийн аман хэл*” хэмээн нэрлэж болох байна. Учир нь эдүгээ “Монгол улсын хүн амын 20,1 хувь нь фэйсбүүкийн хэрэглэгч болжээ. Хэрэглэгчийн тоо 640 мянгад хүрч өмнөх оноос 53 хувиар өссөнөөс 580 мянга нь Улаанбаатар хотын хэрэглэгч байна” (Цагаан ном, 2014: 30). Мөн нийгмийн сүлжээний бас нэгэн том хэрэгсэл твиттерт бүртгэлтэй монгол хэрэглэгчид 100-120 мянга орчим, үүнээс идэвхтэй нь 30-40 орчим мянга байна. Нийгмийн сүлжээний хэрэглэгчдийг харахад 20-40 насны залуучууд хамгийн идэвхтэй, ялангуяа сэтгүүлчид, улс төрчид гэх мэт нийгмийн хамгийн нөлөөтэй хэсгийнхэн байдаг учраас интернэт орчин нь ард түмний өнөө цагийн хэлний хөгжил, хувиралтын байдлыг төлөөлж чадах нэгэн орчин мөн хэмээн үзэж байна.

Ном зүй

1. **Баабар, Б.** 2014. Киноны хэл. <http://baabar.niitlech.mn/content/5808.shtml>
2. **Ринчен, Б.** 1961. Монгол ардын аман бичгийн хэл. *Шинжлэх ухааны академийн мэдээ*. №2, У6

3. **Ринчен, Б.** 2015а. Монгол ардын аман бичгийн хэл. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган-V боть*. Уб., Соёмбо принтинг ХХК. х.113-119.
4. **Ринчен, Б.** 2015 б. *Монгол бичгийн хэлний зүй. Удиртгал*. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган-I боть. Уб., Соёмбо принтинг ХХК.
5. **Цагаан ном.** 2014. *Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хөгжил*. Уб
6. **Энхмаа, Б.** 2015. *Интернэтийн хэл шинжлэл*. Уб., Соёмбо принтинг ХХК.
7. https://en.wikipedia.org/wiki/List_of_virtual_communities_with_more_than_100_million_active_users
8. <http://www.statisticbrain.com/twitter-statistics/>

РЕЗЮМЕ

С появлением интернета начался процесс широкого круга изменений протекающих вокруг нас примером чего является язык. Монгольский язык также не остался в стороне от происходящих преобразовательных изменений в сфере интернета. В данной статье устные формы, которые в сфере интернета передаются посредством письма мы обозначили как “письменно-устная речь”.

Уг өгүүлэл 2015 онд “Хэл зохиол судлал” 8 (40) сэтгүүлд нийтлэгдэв.